



ТӨСЛИЙН АЖЛЫН БҮСЭД ТЕХНОЛОГИЙН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙГ ЗОХИЦУУЛАХ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэ журмын зорилго нь төслийн ажлын бүсэд технологийн замын хөдөлгөөнийг зохицуулах, аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөний чиглэл, зохион байгуулалтыг тодорхойлоход оршино.
- 1.2. Технологийн зам нь төслийн хүрээнд хэрэгжих барилга угсралтын ажилд шаардлагатай ажилтан, материал, тоног төхөөрөмжийг тээвэрлэх зориулалттай түр зам байх бөгөөд гадны тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхийг хориглоно.
- 1.3. Энэхүү журам нь төслийн захиалагч, гүйцэтгэгч, зөвлөх, хяналтын байгууллага болон төслийн ажлын бүсэд үйл ажиллагаа явуулж буй бүх этгээдэд үйлчилнэ.
- 1.4. Журмаар зохицуулаагүй асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, ажлын горим, зааврын дагуу шийдвэрлэнэ. Журам нь төслийг хэрэгжүүлэх хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 1.5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор замын хаалт, хөвөө, хамгаалалтын далан байгуулах, замын тэмдэг, тэмдэглэгээ хийх зэрэг арга хэмжээг төлөвлөж байршуулна.
- 1.6. Технологийн замыг ашиглагч байгууллагууд замын арчилгаа, засвар, усалгаа үйлчилгээг хариуцан гүйцэтгэж, эвдрэл гэмтлийг тухай бүр засварлах арга хэмжээ авна.

Хоёр. Тээврийн хэрэгслийн техникийн шаардлага

- 2.1. Төслийн ажлын бүсэд замын хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгсэл нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 2.1.1 Тээврийн хэрэгсэл нь байгууллагын дотоод дүрэм, журам, зааврын дагуу бичиг баримтын зөрчилгүй, техникийн улсын үзлэг, оношилгоо, даатгалд хамрагдсан байна.
 - 2.1.2 Засвар үйлчилгээ болон техникийн үзлэгийг тогтмол хийж, холбогдох баримтжуулалтыг бүрдүүлсэн байна.
 - 2.1.3 Тээврийн хэрэгслийн төрөлжсөн үзлэгийн хуудсыг тогтмол хөтөлж, хяналт тавьдаг байна.
 - 2.1.4 Суудлын автомашин нь бартаат зам туулах чадвартай, дөрвөн дугуйн хөтлөгчтэй, зүүн талдаа жолооны хүрдтэй, үзэгдэх байдлыг сайжруулах зорилгоор цайвар (цагаан, шаргал) өнгөтэй байна.

- 2.1.5 Монгол Улсад мөрдөгдөж буй галын аюулгүй байдлын хууль, дүрэм, стандартын шаардлагад нийцсэн 2–6 кг-ын галын хор 2-оос доошгүй ширхэгтэй байна.
- 2.1.6 Бүх талаас ил харагдахуйц байрлалд суурилуулсан дохиоллын маягтай байх бөгөөд линзний диаметр 12 см-ээс багагүй, өндөр нь 15 см-ээс багагүй, хангалттай гэрэлтэгчтэй байна.
- 2.1.7 Богино долгионы радио станцаар тоноглогдсон байна.
- 2.1.8 Тухайн тээврийн хэрэгсэлд тохирсон дугуйн эвүүр 2-оос доошгүй ширхэгтэй байна.
- 2.1.9 Суудлын автомашин нь хоёр хажуу талдаа тууш байрласан, өргөн нь 50–75 мм, урт нь 200 мм-ээс багагүй хэмжээтэй гэрэл ойлгогч шар өнгийн хуулгатай байна.
- 2.1.10 Автогрейдер, бульдозер, автосамосвал зэрэг хүнд машин механизм нь 80 мм-ээс багагүй өргөнтэй гэрэлтдэг хуулгыг тухайн техникийн овор хэмжээг илтгэх байдлаар байрлуулсан байна.
- 2.1.11 Дугуйт ачигч, автосамосвал болон бусад механизм нь ардаа зай мэдрэгч болон ухрах үед ажиллах дуут дохио болон зай мэдрэгчтэй байна.
- 2.1.12 Онцгой байдал, эмнэлгийн тусламж үйлчилгээ, ослын үед ажиллах тээврийн хэрэгсэл тусгай дуут болон гэрлэн дохиогоор тоноглогдсон байх бөгөөд жолооч нь холбогдох сургалт, зааварчилгаанд хамрагдсан байна.

Гурав. Замын хөдөлгөөнд оролцоход баримтлах шаардлага

- 3.1. Төслийн ажлын бүсэд замын хөдөлгөөнд оролцох бүх жолооч, оператор нь Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон Замын хөдөлгөөний дүрмийг мөрдөнө.
- 3.2. Жолооч, оператор нь эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж тэнцсэн, зохих сургалтад хамрагдсан, холбогдох ангиллын жолооны үнэмлэх, мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээтэй, жолоочийн хариуцлагын даатгалтай байна.
- 3.3. Жолооч нь ажилд гарахын өмнө хоногт 8 цагаас доошгүй хугацаанд амарч, нойр авсан байна.
- 3.4. Жолооч нь ажил эхлэхийн өмнө хариуцсан тээврийн хэрэгсэлдээ өдөр тутмын техникийн үзлэгийг бүрэн хийж, хэвийн ажиллагааг хангана.
- 3.5. Автомашин, техник хэрэгсэлд суух, буухдаа “гурван цэгийн дүрэм”-ийг мөрдөнө.
- 3.6. Жолооч нь цаг агаар, орчны нөхцөл болон замын байдлыг харгалзан тээврийн хэрэгслийг аюулгүй, зохистой жолоодно.

Дөрөв. Хөдөлгөөнд оролцоход анхаарах зүйл

- 4.1. Автосамосвалын араас явж буй тээврийн хэрэгсэл нь хамгийн багадаа 30 м буюу 3 автомашины зай барина. Замын нөхцөл хүндрэлтэй тохиолдолд зайг 50 м-ээс багагүй байлгана.
- 4.2. Ачих, буулгах ажиллагаа гүйцэтгэж буй автосамосвал нь экскаваторын ажлын тойрог (50 метрийн радиус), мөн авто ачигч, бульдозерын маневрын бүсэд зөвхөн шаардлагатай тохиолдолд нэвтэрнэ.
- 4.3. Хөнгөн тээврийн хэрэгсэл болон явган хүн нь зөвхөн операторын зөвшөөрлөөр хүнд механизмын ажлын бүс (50 м радиус)-д нэвтэрнэ. Нэвтрэхээс өмнө тухайн техникийн ажлын эд ангийг газарт бүрэн буулгаж, хөдөлгөөнгүй болгосон байна.
- 4.4. Төслийн ажлын бүсэд тээврийн хэрэгсэл эвдэрч зогссон тохиолдолд жолооч, оператор нь шууд удирдлага, мастер болон ойр орчимд ажиллаж буй бусад техник хэрэгслийн операторт нэн даруй мэдээлж, аюулгүй байдлыг хангана.
- 4.5. Хаалт, хязгаарлалт тогтоосон, нэвтрэхийг хориглосон бүсэд ямар ч тохиолдолд нэвтрэхийг хориглоно.
- 4.6. Хөдөлгөөнд оролцож байх үед араа (авцуулах холбоо)-г салгахыг хориглоно.
- 4.7. Авто ачигч, автогрейдер, бульдозер зэрэг техникүүд нь хөдөлгөөнд оролцохдоо ажлын эд ангиа газраас 0.5–1.0 м-ийн өндөрт өргөсөн байна.
- 4.8. Автосамосвал нь хөдөлгөөнд оролцох үедээ тэвшээ бүрэн буулгасан, өдөр, шөнийн аль ч цагт их гэрэл болон оврын гэрлийг асаасан байна.
- 4.9. Шатахуун түгээх цэгээс цэнэглэлт хийхдээ дарааллын журмыг баримталж, суудлын автомашинуудын хоорондын зайг 2 м-ээс, ачааны автомашинуудын хоорондын зайг 4 м-ээс багагүй байлгана.
- 4.10. Жолооч, оператор нь тээврийн хэрэгслийн кабинаас буух үедээ эргэн тойрны нөхцөл байдлыг шалгаж, ойртон ирж буй техник хэрэгслийн операторт өөрийн байршлыг мэдэгдэнэ.

Тав. Хөдөлгөөнд оролцоход хориглох зүйл

- 5.1. Хөнгөн тээврийн хэрэгсэл нь технологийн тээврийн хэрэгслийн аюулгүй зай (50 м)-д тухайн техникийн операторын зөвшөөрөлгүй нэвтрэх, мөн хэт ойр зайд дагаж хөдөлгөөнд оролцохыг хориглоно.
- 5.2. Ачаатай техник хэрэгслийг гүйцэж түрүүлэхдээ богино долгионы радио станцаар урьдчилан мэдэгдэж, эерэг холбоо тогтоосны дараа гүйцэтгэнэ. Зөвшөөрөлгүй гүйцэж түрүүлэхийг хориглоно.
- 5.3. Хөнгөн тээврийн хэрэгслийн жолооч нь хүнд машин, механизмын сохор бүсэд зэрэгцэн явахыг хориглоно. Хөнгөн тээврийн хэрэгслийн жолооч нь хүнд машин, механизмын урд болон хойд талд аюулгүй зай баримтлахгүйгээр ойр зогсохыг хориглоно.

- 5.4. Сургалтын үнэлгээ хийхээс бусад тохиолдолд авто ачигч, автогрейдер, бульдозер, экскаватор зэрэг хүнд машин, механизмд зөвшөөрөлгүй хүн суулгахыг хориглоно.
- 5.5. Хаалт, хязгаарлалт тогтоосон, нэвтрэхийг хориглосон бүсэд ямар ч тохиолдолд нэвтрэхийг хориглоно.
- 5.6. Тогтоосон маршрутаас гадуур явах, зөвшөөрөгдсөн буулгах цэгээс өөр газар ачаа буулгах зэрэг журамд заагаагүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 5.7. Үзэгдэх орчин хязгаарлагдмал бүсэд буцаж эргэх үйлдэл хийхийг хориглоно.
- 5.8. Өрөмдлөг, тэсэлгээний талбайд холбогдох ажил хариуцсан мастерын зөвшөөрөлгүй нэвтрэхийг хориглоно.
- 5.9. Технологийн зам болон түүний дагуу явган зорчихыг хориглоно.
- 5.10. Дозер, ковш, грейдер, индүү болон бусад туслах техникүүдийн гишгүүр, тавцан, шанага зэрэг зориулалтын бус эд анги дээр суух, зогсох, зорчихыг хатуу хориглоно.
- 5.11. Гаднын зорчигч, нийтийн зорчигч тээврийн хэрэгсэл болон иргэдийн автомашиныг технологийн замаар зорчихыг хориглоно.

Зургаа. Төслийн ажлын бүсэд ачаа тээвэрлэлт

- 6.1. Ачаа тээвэрлэлтийг гүйцэтгэхдээ Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийг мөрдөнө.
- 6.2. Тээвэрлэж буй ачаа нь жолоочийн үзэгдэх орчинг хязгаарлахгүй, хөдөлгөөнд оролцох үед унах, чирэгдэх зэргээр бусдад аюул учруулахгүйгээр бэхлэгдсэн байна.
- 6.3. Тээврийн хэрэгслийн тогтвортой байдлыг алдагдуулахуйц өндөрлөж ачихгүй, мөн даац хэтрүүлэхгүй байна.
- 6.4. Тэсэрч дэлбэрэх, амархан шатах болон бусад аюултай ачааг тээвэрлэхдээ даацын 2/3-оос хэтрүүлэхгүй байх бөгөөд тэвш нь мод, резин зэрэг оч үүсгэхгүй материалаар бүрсэн, янданд оч дарагч суурилуулсан байна.
- 6.5. Зориулалтын бус тээврийн хэрэгсэл, машин механизмаар ачаа, бараа, материал тээвэрлэхийг хориглоно.

Долоо. Хөдөлгөөний давуу эрх

- 7.1. Жолооч нь уулзвар нэвтрэхдээ замын болон орчны нөхцөл байдлыг зөв үнэлж, тухайн нөхцөлд тохируулан тээврийн хэрэгслийг аюулгүй нэвтрүүлнэ. Технологийн замын уулзваруудад замын тэмдэг, тэмдэглэгээг байрлуулсан байх бөгөөд бүх тээврийн хэрэгсэл тэдгээрийг мөрдөж хөдөлгөөнд оролцоно.

- 7.2. Замын тэмдэг, тэмдэглэгээ байхгүй тохиолдолд тээврийн хэрэгслүүд дараах дарааллын дагуу зам тавьж өгнө. Үүнд:
- 7.2.1. Онцгой тохиолдолд аваарын дохио асаасан эмнэлгийн болон гал унтраах тээврийн хэрэгсэлд;
 - 7.2.2. Тэсэлгээний ажилд ашиглагдаж буй тээврийн хэрэгсэлд (гэрлэн дохио асаасан, хамгаалалттай зорчиж байгаа үед);
 - 7.2.3. Ачаатай тээврийн хэрэгсэлд;
 - 7.2.4. Ижил даац, оврын автосамосвал нэг зам ашиглаж байгаа үед өгсүүр чиглэлд зорчиж буй автосамосвалд;
 - 7.2.5. Хоёр өөр түвшнээс ачилт хийж, уулзварт зэрэг нэвтрэх нөхцөлд “сохор” талд байрласан автосамосвал нь нөгөөдөө зам тавьж өгнө;
 - 7.2.6. Машин механизмын жолооч (оператор) уулзварт зэрэг нэвтэрсэн тохиолдолд баруун гар талд байрлах тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө;
 - 7.2.7. Технологийн замд ажлын горимоор ажиллаж буй (хутгаа буулган ажиллаж байгаа) дозер, автогрейдер болон усалгаа хийж буй усны машинд;
 - 7.2.8. Суудлын автомашин нь бүх төрлийн хүнд машин, механизмд зам тавьж өгнө.

Найм. Гүйцэж түрүүлэх үйл ажиллагаа

- 8.1. Гинжит техник хөдөлгөөнд оролцож байх үед зам дээр эвдэрсэн техник, эсхүл зам засварын ажил гүйцэтгэж буй грейдер байвал радио станцаар холбогдож зөвшөөрөл авч, үзэгдэх орчин чөлөөтэй эсэх, уулзвар болон эргэлтийн нөхцөл, аюулгүй зайлах боломжийг бүрэн баталгаажуулсны дараа гүйцэж түрүүлнэ.
- 8.2. Үзэгдэх орчин хязгаарлагдаагүй, шулуун замын нөхцөлд урд яваа тээврийн хэрэгсэл нь тогтоосон хурдны хязгаарын 2/3-аас доош хурдтай хөдөлж байгаа тохиолдолд гүйцэж түрүүлэхийг зөвшөөрнө. Энэхүү үйлдлийг зөвхөн бага оврын суудлын автомашинаар гүйцэтгэх бөгөөд радио холбоогоор урьдчилан зөвшөөрөл авсан байна.

Ес. Тээврийн хэрэгсэл, машин механизмыг зогсоолд байрлуулах

- 9.1. Тээврийн хэрэгслийг зогсоолд байрлуулах, түр зогсолт хийх тухай ээлжийн ахлагчид урьдчилан мэдэгдэнэ.
- 9.2. Машин механизм эвдрэх болон бусад яаралтай шалтгаанаас бусад тохиолдолд булан, тойруу, үзэгдэх орчин хязгаарлагдмал хэсэгт удаан хугацаагаар зогсох, байрлуулахыг хориглоно.
- 9.3. Тээврийн хэрэгслийг зөвхөн урагш хөдөлж гарах боломжтой, тэгш, аюулгүй талбайд байрлуулна. Мөргөцгийн нүүрний өндрийг хоёр дахин

нэмэгдүүлсэн зайнаас дотогш болон карьерын хананаас 20 метрийн дотор тээврийн хэрэгсэл байрлуулахыг хориглоно.

- 9.4. Онцгой нөхцөл байдал, эсхүл эвдрэлийн улмаас автосамосвалыг налуу газар зогсоох шаардлагатай болсон тохиолдолд оператор нь тээврийн хэрэгслийг орхихоос өмнө дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:
 - 9.4.1. Зогсоосон байршлаа бусад оператор, ажилтнуудад мэдээлэх;
 - 9.4.2. Урд дугуйг хашлага буюу хөмсөг тал руу эргүүлэх;
 - 9.4.3. Трансмиссыг “нейтраль” байрлалд шилжүүлэх;
 - 9.4.4. Зогсоолын тормосыг бүрэн татах;
 - 9.4.5. Налуугийн доод талын дугуйнд эвүүр (түгжээ) байрлуулах;
 - 9.4.6. Ослын дохиоллыг асаах;
- 9.5. Хүнд машин, механизмыг байрлуулах үед хутга, соёо, шанага зэрэг газартай харьцах бүх хөдөлгөөнт эд ангийг газарт бүрэн буулгаж байрлуулна.
- 9.6. Хөнгөн тээврийн хэрэгслийг ажлын бүсэд байрлуулахдаа хүнд машин, механизмын операторт харагдахуйц, аюулгүй талбайд, зохих зай баримтлан зэрэгцээ байрлуулна.

Арав. Хурдны зохицуулалт

- 10.1. Жолооч, оператор нь төслийн ажлын бүсэд замын хөдөлгөөнийг зохицуулах зорилгоор байршуулсан замын тэмдэг, тэмдэглэгээг байнга мөрдөнө.
- 10.2. Технологийн замд мөрдөх хурдны дээд хязгаар нь дараах байдалтай байна. Үүнд:

№	Замын хэсэг	Хурд (км/ц)
1	Технологийн зам	40
2	Карьер, ачилт/буулгалт	15–20
3	Засварын бүс	5–10

- 10.3. 40 км/ц хурдтай үед тээврийн хэрэгсэл бүрэн зогсох хүртэл ойролцоогоор 20 метр зам туулдаг болохыг харгалзан үзэж, шаардлагатай тохиолдолд хурдыг бууруулах болон нэмэлт хязгаарлалт тогтоох эрхийг захиалагч болон ХАБЭА-н ажилтан хэрэгжүүлнэ.
- 10.4. Төслийн замын хөдөлгөөний журам болон ХАБЭА-н шаардлагыг зөрчсөн тохиолдолд холбогдох байгууллагын дотоод журамд заасан хариуцлага, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Арван нэг. Өөрчлөлтийг төлөвлөх үе шат

- 11.1. Замын хөдөлгөөнд өөрчлөлт оруулах төлөвлөгөөнд тухайн өөрчлөлтийн зураг, зам хаах болон нээх хугацаа, хэрэгжүүлэх үе шатны мэдээллийг тодорхой тусгана.

- 11.2. Төслийн ажлын бүсэд хэрэгжүүлэх замын хөдөлгөөний өөрчлөлтийн төлөвлөгөөг төслийн талбайн ахлах баталгаажуулна.
- 11.3. Зам хаах тухай мэдэгдлийг хаахаас 24 цагийн өмнө төслийн хяналтын удирдлага болон холбогдох гүйцэтгэгч байгууллагуудад хүргүүлнэ.
- 11.4. Замын хөдөлгөөний өөрчлөлтийн төлөвлөлтөд ХАБЭА-ны мэргэжилтний санал, зөвлөмжийг заавал тусгана.
- 11.5. Шинээр зам байгуулах, газар хөндөх шаардлагатай үүссэн тохиолдолд холбогдох “Газар хөндөх зөвшөөрөл”-ийг авч, Байгаль орчны ажилтанд мэдэгдэн “Шимт хөрстэй ажиллах журам”-д заасны дагуу зөвшөөрөл авна.
- 11.6. Тэсэлгээний ажил явагдах үед тэсэлгээний инженерийн тогтоосон аюулгүйн зайд бүх тээврийн хэрэгсэл, ажилтныг гаргаж, замын хөдөлгөөнийг түр зогсоон хяналт тавина.
- 11.7. Зочин, хөрөнгө оруулагч болон хоёр улсын албан ёсны төлөөлөгчид ажлын явцтай танилцах тохиолдолд захиалагч байгууллагын удирдлагад 24 цагийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

Арван хоёр. Хууль, эрх зүйн үндэслэл

- 12.1. Энэ журмыг Монгол Улсын дараах хууль тогтоомж, дүрэм, стандартын хүрээнд боловсруулан мөрдөнө. Үүнд:
- 12.2. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-28 дугаар зүйл (Ажил олгогчийн эрх, үүрэг);
- 12.3. “Авто замын тухай хууль”- 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэг;
- 12.4. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”- 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг;
- 12.5. “Замын хөдөлгөөний дүрэм” (Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 275 дугаар тогтоол);
- 12.6. Холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, техникийн нөхцөл.

--ooOoo--

Журмын төслийг танилцуулж, санал авсан байдал

Д/д	Танилцуулсан байгууллага	Өгсөн санал	Тайлбар
1	"Жинжий майнинг" ХХК	1. Хурдны дээд хязгаарыг 50 км/ц болгох; 2. Дозер, ковш, грейдер, индүү болон туслах техникүүдийн гишгүүр, тавцан, шанага зэрэг зориулалтын бус эд анги дээр суух, зогсох, зорчихыг хатуу хориглох; 3. Гаднын зорчигч, зорчигч тээврийн хэрэгсэл болон иргэдийн автомашиныг технологийн замаар зорчуулахгүй байх.	1. Захиалагч тал болох "Тавантолгой төмөр зам" ХХК нь аюулгүй ажиллагааны үндэслэлээр хурдны дээд хязгаарыг 40 км/ц байхаар тогтоох саналтай бөгөөд энэ асуудлыг Хуулийн хэлтэст хянуулж, удирдлагын шийдвэрээр эцэслэнэ. 2. Саналыг тусгасан 3. Саналыг тусгасан
2	"Сэмбэ констракшн" ХХК	Саналгүй	
3	"Хятадын төмөр замын барилгын гүүрийн инженерийн товчоо групп монголиа" ХХК /CRCC/	Саналгүй	

ТУШААЛЫН ТӨСӨЛД САНАЛ АВАХ ХУУДАС

2025 оны 04 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Тушаалын нэр: Журам батлах тухай

Тушаалын төрөл: ☒ "А" (Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр)
☐ "Б" (Хүний нөөцийн чиглэлээр)

Хавсралт хуудасны тоо: ...

№	Албан тушаал, нэр	Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх	Шийдвэр гаргах ажиллагааны оролцоо	Санал	Гарын үсэг, огноо
1.	ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Х.ПҮРЭВЖАРГАЛ	—	—	✓	
2.	ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА Э.ТҮМЭНЖАРГАЛ	—	—	санал түгээгдсэн	
3.	ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА Д.ЭНХБАТ	—	—	сөвчингүй	
4.	САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН ДАРГА Д.БАЛДАНГОМБО	—	—	1. ХАХЭАА 2. Дамсруулагч 3. ТИХХ Р.Отгонсүрэн наран санал заавал туслах. (Санал тусгасан)	 2025.05.01
5.	ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ АУДИТОР С.УДВАЛ	—	—	саналгүй	
6.	АХЛАХ ХУУЛЬЧ Б.БАТНАЙРАМДАЛ		Санал огор	Санал тусгасан	 2025.05.01

Нэгжийн нэр: Төлөвлөлтийн хэлтэс

Боловсруулсан ажилтны овог, нэр:

Ц.Оюунгэрэл

САНАЛ БИЧИХ ХУУДАС

- Үүдсийн андаа засах
- Дураарлант амхааргах

**ТӨСЛИЙН АЖЛЫН БҮСЭД ТЕХНОЛОГИЙН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙГ
ЗОХИЦУУЛАХ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЖУРАМ
/ТӨСӨЛ/**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэ журмын зорилго нь төслийн ажлын бүсэд технологийн замын хөдөлгөөнийг зохицуулах, аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөний чиглэл, зохион байгуулалтыг тодорхойлоход оршино.
- 1.2. Технологийн зам нь төслийн хүрээнд хэрэгжих барилга угсралтын ажилд шаардлагатай ажилтан, материал, тоног төхөөрөмжийг тээвэрлэх зориулалттай түр зам байх бөгөөд гадны тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхийг хориглоно.
- 1.3. Энэхүү журам нь төслийн захиалагч, гүйцэтгэгч, зөвлөх, хяналтын байгууллага болон төслийн ажлын бүсэд үйл ажиллагаа явуулж буй бүх этгээдэд үйлчилнэ.
- 1.4. Журмаар зохицуулаагүй асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, ажлын горим, зааврын дагуу шийдвэрлэнэ. Журам нь төслийг хэрэгжүүлэх хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 1.5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор замын хаалт, хөвөө, хамгаалалтын далан байгуулах, замын тэмдэг, тэмдэглэгээ хийх зэрэг арга хэмжээг төлөвлөж байршуулна.
- 1.6. Технологийн замыг ашиглагч байгууллагууд замын арчилгаа, засвар, усалгаа үйлчилгээг хариуцан гүйцэтгэж, эвдрэл гэмтлийг тухай бүр засварлах арга хэмжээ авна.

Хоёр. Тээврийн хэрэгслийн техникийн шаардлага

- 2.1. Төслийн ажлын бүсэд замын хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгсэл нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 2.1.1 Тээврийн хэрэгсэл нь байгууллагын дотоод дүрэм, журам, зааврын дагуу бичиг баримтын зөрчилгүй, техникийн улсын үзлэг, оношилгоо, даатгалд хамрагдсан байна.
 - 2.1.2 Засвар үйлчилгээ болон техникийн үзлэгийг тогтмол хийж, холбогдох баримтжуулалтыг бүрдүүлсэн байна.
 - 2.1.3 Тээврийн хэрэгслийн төрөлжсөн үзлэгийн хуудсыг тогтмол хөтөлж, хяналт тавьдаг байна.

- 2.1.4 Суудлын автомашин нь бартаат зам туулах чадвартай, дөрвөн дугуйн хөтлөгчтэй, зүүн талдаа жолооны хүрдтэй, үзэгдэх байдлыг сайжруулах зорилгоор цайвар (цагаан, шаргал) өнгөтэй байна.
- 2.1.5 Монгол Улсад мөрдөгдөж буй галын аюулгүй байдлын хууль, дүрэм, стандартын шаардлагад нийцсэн 2–6 кг-ын галын хор 2-оос доошгүй ширхэгтэй байна.
- 2.1.6 Бүх талаас ил харагдахуйц байрлалд суурилуулсан дохиоллын маягтай байх бөгөөд линзний диаметр 12 см-ээс багагүй, өндөр нь 15 см-ээс багагүй, хангалттай гэрэлтэгчтэй байна.
- 2.1.7 Богино долгионы радио станцаар тоноглогдсон байна.
- 2.1.8 Тухайн тээврийн хэрэгсэлд тохирсон дугуйн эвүүр 2-оос доошгүй ширхэгтэй байна.
- 2.1.9 Суудлын автомашин нь хоёр хажуу талдаа тууш байрласан, өргөн нь 50–75 мм, урт нь 200 мм-ээс багагүй хэмжээтэй гэрэл ойлгогч шар өнгийн хуулгатай байна.
- 2.1.10 Автогрейдер, бульдозер, автосамосвал зэрэг хүнд машин механизм нь 80 мм-ээс багагүй өргөнтэй гэрэлтдэг хуулгыг тухайн техникийн овор хэмжээг илтгэх байдлаар байрлуулсан байна.
- 2.1.11 Дугуйт ачигч, автосамосвал болон бусад механизм нь ардаа зай мэдрэгч болон ухрах үед ажиллах дуут дохио болон зай мэдрэгчтэй байна.
- 2.1.12 Онцгой байдал, эмнэлгийн тусламж үйлчилгээ, ослын үед ажиллах тээврийн хэрэгсэл тусгай дуут болон гэрлэн дохиогоор тоногдсон байх бөгөөд жолооч нь холбогдох сургалт, зааварчилгаанд хамрагдсан байна.

Гурав. Замын хөдөлгөөнд оролцоход баримтлах шаардлага

- 3.1. Төслийн ажлын бүсэд замын хөдөлгөөнд оролцох бүх жолооч, оператор нь Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон Замын хөдөлгөөний дүрмийг мөрдөнө.
- 3.2. Жолооч, оператор нь эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж тэнцсэн, зохих сургалтад хамрагдсан, холбогдох ангиллын жолооны үнэмлэх, мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээтэй, жолоочийн хариуцлагын даатгалтай байна.
- 3.3. Жолооч нь ажилд гарахын өмнө хоногт 8 цагаас доошгүй хугацаанд амарч, нойр авсан байна.
- 3.4. Жолооч нь ажил эхлэхийн өмнө хариуцсан тээврийн хэрэгсэлдээ өдөр тутмын техникийн үзлэгийг бүрэн хийж, хэвийн ажиллагааг хангана.
- 3.5. Автомашин, техник хэрэгсэлд суух, буухдаа “гурван цэгийн дүрэм”-ийг мөрдөнө.
- 3.6. Жолооч нь цаг агаар, орчны нөхцөл болон замын байдлыг харгалзан тээврийн хэрэгслийг аюулгүй, зохистой жолоодно.

Дөрөв. Хөдөлгөөнд оролцоход анхаарах зүйл

- 4.1. Автосамосвалын араас явж буй тээврийн хэрэгсэл нь хамгийн багадаа 30 м буюу 3 автомашины зай барина. Замын нөхцөл хүндрэлтэй тохиолдолд зайг 50 м-ээс багагүй байлгана.
- 4.2. Ачих, буулгах ажиллагаа гүйцэтгэж буй автосамосвал нь экскаваторын ажлын тойрог (50 метрийн радиус), мөн авто ачигч, бульдозерын маневрын бүсэд зөвхөн шаардлагатай тохиолдолд нэвтэрнэ.
- 4.3. Хөнгөн тээврийн хэрэгсэл болон явган хүн нь зөвхөн операторын зөвшөөрлөөр хүнд механизмын ажлын бүс (50 м радиус)-д нэвтэрнэ. Нэвтрэхээс өмнө тухайн техникийн ажлын эд ангийг газарт бүрэн буулгаж, хөдөлгөөнгүй болгосон байна.
- 4.4. Төслийн ажлын бүсэд тээврийн хэрэгсэл эвдэрч зогссон тохиолдолд жолооч, оператор нь шууд удирдлага, мастер болон ойр орчимд ажиллаж буй бусад техник хэрэгслийн операторт нэн даруй мэдээлж, аюулгүй байдлыг хангана.
- 4.5. Хаалт, хязгаарлалт тогтоосон, нэвтрэхийг хориглосон бүсэд ямар ч тохиолдолд нэвтрэхийг хориглоно.
- 4.6. Хөдөлгөөнд оролцож байх үед араа (авцуулах холбоо)-г салгахыг хориглоно.
- 4.7. Авто ачигч, автогрейдер, бульдозер зэрэг техникүүд нь хөдөлгөөнд оролцохдоо ажлын эд ангиа газраас 0.5–1.0 м-ийн өндөрт өргөсөн байна.
- 4.8. Автосамосвал нь хөдөлгөөнд оролцох үедээ тэвшээ бүрэн буулгасан, өдөр, шөнийн аль ч цагт их гэрэл болон оврын гэрлийг асаасан байна.
- 4.9. Шатахуун түгээх цэгээс цэнэглэлт хийхдээ дарааллын журмыг баримталж, суудлын автомашинуудын хоорондын зайг 2 м-ээс, ачааны автомашинуудын хоорондын зайг 4 м-ээс багагүй байлгана.
- 4.10. Жолооч, оператор нь тээврийн хэрэгслийн кабинаас буух үедээ эргэн тойрны нөхцөл байдлыг шалгаж, ойртон ирж буй техник хэрэгслийн операторт өөрийн байршлыг мэдэгдэнэ.

Тав. Хөдөлгөөнд оролцоход хориглох зүйл

- 5.1. Хөнгөн тээврийн хэрэгсэл нь технологийн тээврийн хэрэгслийн аюулгүй зай (50 м)-д тухайн техникийн операторын зөвшөөрөлгүй нэвтрэх, мөн хэт ойр зайд дагаж хөдөлгөөнд оролцохыг хориглоно.
- 5.2. Ачаатай техник хэрэгслийг гүйцэж түрүүлэхдээ богино долгионы радио станцаар урьдчилан мэдэгдэж, эерэг холбоо тогтоосны дараа гүйцэтгэнэ. Зөвшөөрөлгүй гүйцэж түрүүлэхийг хориглоно.
- 5.3. Хөнгөн тээврийн хэрэгслийн жолооч нь хүнд машин, механизмын сохор бүсэд зэрэгцэн явахыг хориглоно. Хөнгөн тээврийн хэрэгслийн жолооч нь хүнд машин, механизмын урд болон хойд талд аюулгүй зай баримтлахгүйгээр ойр зогсохыг хориглоно.

- 5.4. Сургалтын үнэлгээ хийхээс бусад тохиолдолд авто ачигч, автогрейдер, бульдозер, экскаватор зэрэг хүнд машин, механизмд зөвшөөрөлгүй хүн суулгахыг хориглоно.
- 5.5. Хаалт, хязгаарлалт тогтоосон, нэвтрэхийг хориглосон бүсэд ямар ч тохиолдолд нэвтрэхийг хориглоно.
- 5.6. Тогтоосон маршрутаас гадуур явах, зөвшөөрөгдсөн буулгах цэгээс өөр газар ачаа буулгах зэрэг журамд заагаагүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 5.7. Үзэгдэх орчин хязгаарлагдмал бүсэд буцаж эргэх үйлдэл хийхийг хориглоно.
- 5.8. Өрөмдлөг, тэсэлгээний талбайд холбогдох ажил хариуцсан мастерын зөвшөөрөлгүй нэвтрэхийг хориглоно.
- 5.9. Технологийн зам болон түүний дагуу явган зорчихыг хориглоно.
- 5.10. Дозер, ковш, грейдер, индүү болон бусад туслах техникүүдийн гишгүүр, тавцан, шанага зэрэг зориулалтын бус эд анги дээр суух, зогсох, зорчихыг хатуу хориглоно.
- 5.11. Гаднын зорчигч, нийтийн зорчигч тээврийн хэрэгсэл болон иргэдийн автомашиныг технологийн замаар зорчихыг хориглоно.

Зургаа. Төслийн ажлын бүсэд ачаа тээвэрлэлт

- 6.1. Ачаа тээвэрлэлтийг гүйцэтгэхдээ Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийг мөрдөнө.
- 6.2. Тээвэрлэж буй ачаа нь жолоочийн үзэгдэх орчинг хязгаарлахгүй, хөдөлгөөнд оролцох үед унах, чирэгдэх зэргээр бусдад аюул учруулахгүйгээр бэхлэгдсэн байна.
- 6.3. Тээврийн хэрэгслийн тогтвортой байдлыг алдагдуулахуйц өндөрлөж ачихгүй, мөн даац хэтрүүлэхгүй байна.
- 6.4. Тэсэрч дэлбэрэх, амархан шатах болон бусад аюултай ачааг тээвэрлэхдээ даацын 2/3-оос хэтрүүлэхгүй байх бөгөөд тэвш нь мод, резин зэрэг оч үүсгэхгүй материалаар бүрсэн, янданд оч дарагч суурилуулсан байна.
- 6.5. Зориулалтын бус тээврийн хэрэгсэл, машин механизмаар ачаа, бараа, материал тээвэрлэхийг хориглоно.

Долоо. Хөдөлгөөний давуу эрх

- 7.1. Жолооч нь уулзвар нэвтрэхдээ замын болон орчны нөхцөл байдлыг зөв үнэлж, тухайн нөхцөлд тохируулан тээврийн хэрэгслийг аюулгүй нэвтрүүлнэ. Технологийн замын уулзваруудад замын тэмдэг, тэмдэглэгээг байрлуулсан байх бөгөөд бүх тээврийн хэрэгсэл тэдгээрийг мөрдөж хөдөлгөөнд оролцоно.

- 7.2. Замын тэмдэг, тэмдэглэгээ байхгүй тохиолдолд тээврийн хэрэгслүүд дараах дарааллын дагуу зам тавьж өгнө. Үүнд:
- 7.2.1. Онцгой тохиолдолд аваарын дохио асаасан эмнэлгийн болон гал унтраах тээврийн хэрэгсэлд;
 - 7.2.2. Тэсэлгээний ажилд ашиглагдаж буй тээврийн хэрэгсэлд (гэрлэн дохио асаасан, хамгаалалттай зорчиж байгаа үед);
 - 7.2.3. Ачаатай тээврийн хэрэгсэлд;
 - 7.2.4. Ижил даац, оврын автосамосвал нэг зам ашиглаж байгаа үед өгсүүр чиглэлд зорчиж буй автосамосвалд;
 - 7.2.5. Хоёр өөр түвшнээс ачилт хийж, уулзварт зэрэг нэвтрэх нөхцөлд “сохор” талд байрласан автосамосвал нь нөгөөдөө зам тавьж өгнө;
 - 7.2.6. Машин механизмын жолооч (оператор) уулзварт зэрэг нэвтэрсэн тохиолдолд баруун гар талд байрлах тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө;
 - 7.2.7. Технологийн замд ажлын горимоор ажиллаж буй (хутгаа буулган ажиллаж байгаа) дозер, автогрейдер болон усалгаа хийж буй усны машинд;
 - 7.2.8. Суудлын автомашин нь бүх төрлийн хүнд машин, механизмд зам тавьж өгнө.

Найм. Гүйцэж түрүүлэх үйл ажиллагаа

- 8.1. Гинжит техник хөдөлгөөнд оролцож байх үед зам дээр эвдэрсэн техник, эсхүл зам засварын ажил гүйцэтгэж буй грейдер байвал радио станцаар холбогдож зөвшөөрөл авч, үзэгдэх орчин чөлөөтэй эсэх, уулзвар болон эргэлтийн нөхцөл, аюулгүй зайлах боломжийг бүрэн баталгаажуулсны дараа гүйцэж түрүүлнэ.
- 8.2. Үзэгдэх орчин хязгаарлагдаагүй, шулуун замын нөхцөлд урд яваа тээврийн хэрэгсэл нь тогтоосон хурдны хязгаарын 2/3-аас доош хурдтай хөдөлж байгаа тохиолдолд гүйцэж түрүүлэхийг зөвшөөрнө. Энэхүү үйлдлийг зөвхөн бага оврын суудлын автомашинаар гүйцэтгэх бөгөөд радио холбоогоор урьдчилан зөвшөөрөл авсан байна.

Ес. Тээврийн хэрэгсэл, машин механизмыг зогсоолд байрлуулах

- 9.1. Тээврийн хэрэгслийг зогсоолд байрлуулах, түр зогсолт хийх тухай ээлжийн ахлагчид урьдчилан мэдэгдэнэ.
- 9.2. Машин механизм эвдрэх болон бусад яаралтай шалтгаанаас бусад тохиолдолд булан, тойруу, үзэгдэх орчин хязгаарлагдмал хэсэгт удаан хугацаагаар зогсох, байрлуулахыг хориглоно.
- 9.3. Тээврийн хэрэгслийг зөвхөн урагш хөдөлж гарах боломжтой, тэгш, аюулгүй талбайд байрлуулна. Мөргөцгийн нүүрний өндрийг хоёр дахин

нэмэгдүүлсэн зайнаас дотогш болон карьерын хананаас 20 метрийн дотор тээврийн хэрэгсэл байрлуулахыг хориглоно.

- 9.4. Онцгой нөхцөл байдал, эсхүл эвдрэлийн улмаас автосамосвалыг налуу газар зогсоох шаардлагатай болсон тохиолдолд оператор нь тээврийн хэрэгслийг орхихоос өмнө дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:
 - 9.4.1. Зогсоосон байршлаа бусад оператор, ажилтнуудад мэдээлэх;
 - 9.4.2. Урд дугуйг хашлага буюу хөмсөг тал руу эргүүлэх;
 - 9.4.3. Трансмиссыг “нейтраль” байрлалд шилжүүлэх;
 - 9.4.4. Зогсоолын тормосыг бүрэн татах;
 - 9.4.5. Налуугийн доод талын дугуйнд эвүүр (түгжээ) байрлуулах;
 - 9.4.6. Ослын дохиоллыг асаах;
- 9.5. Хүнд машин, механизмыг байрлуулах үед хутга, соёо, шанага зэрэг газартай харьцах бүх хөдөлгөөнт эд ангийг газарт бүрэн буулгаж байрлуулна.
- 9.6. Хөнгөн тээврийн хэрэгслийг ажлын бүсэд байрлуулахдаа хүнд машин, механизмын операторт харагдахуйц, аюулгүй талбайд, зохих зай баримтлан зэрэгцээ байрлуулна.

Арав. Хурдны зохицуулалт

- 10.1. Жолооч, оператор нь төслийн ажлын бүсэд замын хөдөлгөөнийг зохицуулах зорилгоор байршуулсан замын тэмдэг, тэмдэглэгээг байнга мөрдөнө.
- 10.2. Технологийн замд мөрдөх хурдны дээд хязгаар нь дараах байдалтай байна. Үүнд:

№	Замын хэсэг	Хурд (км/ц)
1	Технологийн зам	40
2	Карьер, ачилт/буулгалт	15–20
3	Засварын бүс	5–10

- 10.3. 40 км/ц хурдтай үед тээврийн хэрэгсэл бүрэн зогсох хүртэл ойролцоогоор 20 метр зам туулдаг болохыг харгалзан үзэж, шаардлагатай тохиолдолд хурдыг бууруулах болон нэмэлт хязгаарлалт тогтоох эрхийг захиалагч болон ХАБЭА-н ажилтан хэрэгжүүлнэ.
- 10.4. Төслийн замын хөдөлгөөний журам болон ХАБЭА-н шаардлагыг зөрчсөн тохиолдолд холбогдох байгууллагын дотоод журамд заасан хариуцлага, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Арван нэг. Өөрчлөлтийг төлөвлөх үе шат

- 11.1. Замын хөдөлгөөнд өөрчлөлт оруулах төлөвлөгөөнд тухайн өөрчлөлтийн зураг, зам хаах болон нээх хугацаа, хэрэгжүүлэх үе шатны мэдээллийг тодорхой тусгана.

- 11.2. Төслийн ажлын бүсэд хэрэгжүүлэх замын хөдөлгөөний өөрчлөлтийн төлөвлөгөөг төслийн талбайн ахлах баталгаажуулна.
- 11.3. Зам хаах тухай мэдэгдлийг хаахаас 24 цагийн өмнө төслийн хяналтын удирдлага болон холбогдох гүйцэтгэгч байгууллагуудад хүргүүлнэ.
- 11.4. Замын хөдөлгөөний өөрчлөлтийн төлөвлөлтөд ХАБЭА-ны мэргэжилтний санал, зөвлөмжийг заавал тусгана.
- 11.5. Шинээр зам байгуулах, газар хөндөх шаардлагатай үүссэн тохиолдолд холбогдох “Газар хөндөх зөвшөөрөл”-ийг авч, Байгаль орчны ажилтанд мэдэгдэн “Шимт хөрстэй ажиллах журам”-д заасны дагуу зөвшөөрөл авна.
- 11.6. Тэсэлгээний ажил явагдах үед тэсэлгээний инженерийн тогтоосон аюулгүйн зайд бүх тээврийн хэрэгсэл, ажилтныг гаргаж, замын хөдөлгөөнийг түр зогсоон хяналт тавина.
- 11.7. Зочин, хөрөнгө оруулагч болон хоёр улсын албан ёсны төлөөлөгчид ажлын явцтай танилцах тохиолдолд захиалагч байгууллагын удирдлагад 24 цагийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

Арван хоёр. Хууль, эрх зүйн үндэслэл

- 12.1. Энэ журмыг Монгол Улсын дараах хууль тогтоомж, дүрэм, стандартын хүрээнд боловсруулан мөрдөнө. Үүнд:
- 12.2. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-28 дугаар зүйл (Ажил олгогчийн эрх, үүрэг);
- 12.3. “Авто замын тухай хууль”- 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэг;
- 12.4. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”- 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг;
- 12.5. “Замын хөдөлгөөний дүрэм” (Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 275 дугаар тогтоол);
- 12.6. Холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, техникийн нөхцөл.

Журмын төслийг танилцуулж, санал авсан байдал

Д/д	Танилцуулсан байгууллага	Өгсөн санал	Тайлбар
1	"Жинжий майнинг" ХХК	1. Хурдны дээд хязгаарыг 50 км/ц болгох; 2. Дозер, ковш, грейдер, индүү болон туслах техникүүдийн гишгүүр, тавцан, шанага зэрэг зориулалтын бус эд анги дээр суух, зогсох, зорчихыг хатуу хориглох; 3. Гаднын зорчигч, зорчигч тээврийн хэрэгсэл болон иргэдийн автомашиныг технологийн замаар зорчуулахгүй байх.	1. Захиалагч тал болох "Тавантолгой төмөр зам" ХХК нь аюулгүй ажиллагааны үндэслэлээр хурдны дээд хязгаарыг 40 км/ц байхаар тогтоох саналтай бөгөөд энэ асуудлыг Хуулийн хэлтэст хянуулж, удирдлагын шийдвэрээр эцэслэнэ. 2. Саналыг тусгасан 3. Саналыг тусгасан
2	"Сэмбэ констракшн" ХХК	Саналгүй	
3	"Хятадын төмөр замын барилгын гүүрийн инженерийн товчоо групп монголиа" ХХК /CRCC/	Саналгүй	